

Батлан Хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 40 жил, Монгол Улсын шинжлэх ухааны ажилтны одрийг угтсан, Батлан Хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн нэрэмжит, уламжлалт цогцолбор тэмцээн энэ сарын 9-ний одор ҮБХИС-ийн спорт цогцолбор боллоо. Тус тэмцээн анх 2014 онд БХЭШХ-ийн санаачилгаар тус хүрээлэнгийн 35 жилийн ойг угтсан ажлуудын хүрээнд зохион байгуулагдаж байсан спортын цогцолбор тэмцээн оноодор хүрээгээ улам тэлж, хүрээлэнгүүдийн ажилтнуудын хвсэн хвлээдэг вйл ажиллагааны нэг болжээ.

Энэ жилийн тэмцээний онцлог нь Цэргийн эрдэм судлалын 60 жил, БХЭШХ-ийн 40 жил, БХЯ-ны ШУТЗ-ийн 30 жил, Монгол Улсын Шинжлэх ухааны ажилтны одрийг угтан 6 дахь удаагаа амжилттай зохион байгуулагдсан явдал байлаа.

Тэмцээний нээлтийн ажиллагаанд Батлан хамгаалахын дэд сайд, БХЯ-ны ШУТЗ-ийн дарга Т.Дуламдорж, ҮБХИС-ийн захирал, хурандаа П.Жаргалан, БХЭШХ-ийн захирал, хурандаа Б.Монхсайхан, ҮАБЗ-ийн Стратеги судлалын хүрээлэнгийн захирал Б.Энхбайгаль, БСШУСЯ-ны ШУТС-ийн хэлтсийн дарга Б.Ганцэцэг, ҮБХИС-ийн ЭШИХ-ийн дарга, хурандаа Б.Олзийхуяг болон бусад хүрээлэнгүүдийн удирдлагууд оролцлоо.

Батлан хамгаалахын дэд сайд, БХЯ-ны ШУТЗ-ийн дарга Т.Дуламдорж тэмцээнийг нээж хэлсэн үгэндээ: “Оюуны хvнд ходолмор эрхэлдэг эрхэм та бvхнийг цаг заваа гарган уламжлалт цогцолбор тэмцээндээ хүрэлцэн ирсэнд талархаж байна. Эрдэмтэн хvн сайн бvтээл гаргахын тулд эрvvl байх ёстой, эрvvl байхад спорт, ходолгоон чухал. Оноодрийн тэмцээн зорилгоо биелvvlж, та бvхэн нэг одор их спортоор орсолдохийн зэрэгцээ цаашдын хамтын ажиллагаа, харилцаагаа улам бэхжvvlж, vр дvнтэй, амжилттай зохион байгуулагдана гэдэгт итгэлтэй байна. Бvх тамирчиддаа спортын ондор амжилт хvсье” гэлээ.

Тэмцээнд ҮАБЗ-ийн ССХ, БСШУСЯ-ны ШУТС, БХЭШХ, Хууль зvйн vндэсний хүрээлэн, Үндэсний тагнуулын академи, ДХИС-ийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэн, ОБЕГ-ын дэргэдэх Гамшиг судлалын хүрээлэн, ХААИС-ийн Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн, Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн, Эдийн засгийн бодлого, орсолдох чадварын судалгааны тов гэсэн нийт 10 байгууллагын 11

багийн 100 гаруй тамирчид гар бомбог, сагсан бомбог, шатар, ширээний теннис гэсэн спортын 4 торолд хурд хвч, авхаалж самбаагаа сорилоо.

Тус тэмцээний **сагсан бөмбөг**ийн торолд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн тамирчид тэргүүн байр, ДХИС-ийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн тамирчид дэд байр, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн тамирчид гутгаар байр эзэлсэн бол,

Гар бөмбөг

ийн торолд тэргүүн байрыг Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн тамирчид, дэд байрыг Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн тамирчид, гутгаар байрыг ДХИС-ийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн тамирчид эзлэв.

Шатрын тэмцээнд:

Эрэгтэй

Тэргүүн байр: Үндэсний тагнуулын академийн тамирчин Н.Баатархуяг

Дэд байр: Батлан Хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн тамирчин С.Пүрэвдорж

Гутгаар байр: Стратеги судлалын хүрээлэнгийн тамирчин Г.Оноржаргал

Эмэгтэй

Тэргүүн байр: Батлан Хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн тамирчин Н.Ууганцэцэг

Дэд байр: Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн тамирчин Г.Оюунхvv

Гутгаар байр: ДХИС-ийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн тамирчин Уянга

Теннисний тэмцээнд:

Эрэгтэй

Тэргүүн байр- ДХИС-ийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн тамирчин
Ж.Овгонбүргэд

Дэд байр – Үндэсний тагнуулын академийн тамирчин Н.Баатархуяг

Гутгаар байр – Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн тамирчин Баянмонх

Эмэгтэй

Тэргүүн байр – ДХИС-ийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн тамирчин Долгоон

Дэд байр – Үндэсний тагнуулын академийн тамирчин С.Батцэцэг

Гутгаар байр – Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн тамирчин Олзиймаа нар тус тус шалгарлаа.

Цогцолбор тэмцээний 4 торлийн нийт дүнгээр тэргүүн байрыг ДХИС-ийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн баг тамирчид эзэлж, шилжин явах цом, алтан

медаль, монгон шагнал, дэд байрыг Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн баг тамирчид эзэлж, монгон медаль, монгон шагнал, гуравдугаар байрыг Үндэсний тагнуулын академийн баг тамирчид эзэлж, хүрэл медаль, монгон шагнал хүртлээ.

Үндэсний тагнуулын академийн хувьд тус тэмцээнд 3 жил дараалан тэргүүн байр эзэлсэн амжилт гаргасан тул БХЭШХ-ийн 35 жилийн ойн нэрэмжит цомыг үүрд хадгалах эрхэм үүргийг хүлээлээ.